



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАГЧ:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН**

2022 ОН

АГУУЛГА

Нэг.Зорилт	3
Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн Ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/	3
Дөрөв. Бүртгэлийн үйл ажиллагаа	7
4.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :	7
4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:	9
4.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:	10
4.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа	13
Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа	15
Зургаа. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд	17
Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан / Мэдээллийн технологи, программ хангамжийн хүрээнд /	18
Найм. Сургалт, үйл ажиллагаа тайлагнах ажлын хүрээнд	20
Ес. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд	22
Арав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/	25
Арван нэг. Идэвх санаачлага, шинэлэг ажил	31
Арван хоёр. Санал	38

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг.Зорилт

Тус хэлтэс нь 2022 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон Хэлтсийн 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат, дамжлагыг багасгах зорилт тавьж ажилласан болно.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн Ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/

Тус хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээг аймгийн нийт иргэд хөдөлмөрчдөд хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, үйлчилгээний хүртээмжийг нь нэмэгдүүлэх, иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хууль тогтоомжуудыг сурталчлан таниулах, иргэд үйлчлүүлэгчдэд эрх зүйн сургалт зохион байгуулах, улсын бүртгэгч нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэлтсийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Мөн улсын бүртгэгч нарын хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авилага ашиг сонирхолын зөрчил гаргахгүй байх үүднээс төвийн улсын бүртгэгч нарыг сэлгээн ажиллуулах хуваарыг хэлтсийн даргаар батлуулан хариуцлагыг өндөржүүлэн ажиллаж байна.

Иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр гарын авлага болон бусад материалаар хангаж, бүртгэлийн бүрдүүлбэр хангуулсны үндсэн дээр мэдүүлэг хүлээн авах ажиллагаанд улсын бүртгэгчдийг сургасан болно.

Сумдын улсын бүртгэгч нарыг өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, цаашид алдаа дутагдал гаргахгүй байх, хийсэн бүртгэлийг тухай бүр цахимжуулах, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх, цаг ашиглалтанд байнгын хяналт тавин ажиллаж байгаа ба өглөө бүр Spark дотоод сүлжээгээр ирцийн бүртгэлийг хянаж байна. Мэдээлэл шуурхай солилцох үүднээс телеграммаар ирсэн мэдээлэл, үүрэг чиглэлийг сумын улсын бүртгэгч нарт шуурхай хүргэн ажиллаж байна. Мөн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон сумын ЗДТГ-ын даргаас цаг бүртгэлийн хуудсыг авч хэвшсэн болно.

Цахим хуудсанд болон нийгмийн сүлжээний байгууллагын фэйсбук хуудсанд холбоо барих утасны дугаар, цахим шуудан хаяг, цагийн хуваарийг шинэчлэн оруулсан нээлттэй утаснуудыг бичсэн.

Хэвлэгдэж ирсэн иргэний цахим үнэмлэх, гадаад паспортуудыг эздэд нь утсаар мэдэгдэж үйлчлүүлэгчидтэй эргэх холбоотой ажиллаж байна. 16 нас хүрээгүй хүүхдийн паспорт олгохдоо “Хилээр гарах тохиолдолд төрсний гэрчилгээг хамт авч явах тухай санамж” бичиг хавсаргаж өгч үйлчилж байна.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 4/134 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн цахимжуулах ажлыг 2022 оны 1 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн цахимжуулах ажлыг эхлүүлж өдөр тутам баталгаажуулах явцад хяналт тавин ажиллаж байна. Мөн бүртгэсэн төлөвтэй бүртгэлийг хууль журамд заасан ажлын 5 хоногт багтаахгүй тухайн өдөртөө багтаан баталгаажуулалтыг хийж байгаа болно. Мөн газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 02-ний өдрийн 4/9443 тоот албан бичгээр ирүүлсэн эрх бүхий улсын бүртгэгч гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэх, биеийн давхцахгүй өгөгдлийн, шилжилт хөдөлгөөний, нас барсаны бүртгэлийг 11 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн бүртгэж баталгаажуулах ажлыг нэгдсэн журмаар аймгийн төв хэлтэст ирүүлэн сургалт зохион байгуулан зааж өгч бүртгэсэн төлөвтэй бүртгэлийг баталгаажуулж эхлүүлсэн. Чиглэлд заасны дагуу сумдын бүртгэлийг тухай бүр тогтмол шалган хянаж байгаа болно.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 22 дугаар хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн нэгдсэн архивт ИУБ маягтын А талыг иргэний нэрийн эхний үсгээр эрэмбэлсэн байдлаар хүргүүлж байгаа ба энэ талаар Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын даргаас 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 10/1536 тоот чиглэлээр сарын сүүлийн 26-ны өдөр ирүүлж байхаар заасан байгаа.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 18-ний өдрийн 4/4386 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу цахимжуулах ажлыг тухайн өдөртөө багтааж баталгаажуулж байгаа ба буруу зөрүүтэй хийсэн тохиолдолд залруулга хийлгэж зөвтгүүлэн хийж байгаа болно. Чиглэлд заагдсаны дагуу манайд паспорт хэвлэгдэж ирсэний дараа оруулахаар сарын дараа гадаад паспортын материалыг цахимжуулахаар болоод байна. Энэ асуудлын талаар ахлах мэргэжилтэнд тухай бүр танилцуулсан болно.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 4/4585 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлд заагдсан иргэний үнэмлэх хүчингүй болгох эрхийг бүх сумдын улсын бүртгэгч нар нээлгүүлэн хүчингүй болгох ажлыг эхлүүлсэн болно.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 08-ний өдрийн 4/6527 тоот албан бичгээр ирүүлсэн улсын бүртгэлийн байгууллагаас иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахимаар бүртгэх үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-д нэвтрүүлсэнээс хойш 4 бүртгэл ирсэн ба холбогдох нотлох баримтийг хавсаргаж ирүүлээгүй тул татгалзах хариу өгч тухай иргэнд утсаар мэдэгдэн холбогдох нотлох баримтийг авч ирүүлэн өөрийг нь байлцуулан бүртгэлийг хийж өгсөн болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 1/8275 тоот албан бичгээр ирүүлсэн гадаад паспортын зураг авах гэрэлтэй орчин тохижуулан захиалах хүсэлтийг бүртгэх, иргэний зургийг улсын бүртгэгч Олон улсын агаарын тээврийн байгууллага /ИКАО/-ын стандарт шаардлагын дагуу авч иргэний бүртгэлийн мэдээллийн санд оруулах ажлыг 9 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлүүлэн ажиллаж байгаа ба 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 1115 иргэний бүртгэлийг авч тухай бүр баталгаажуулалтыг хийж хэвлэгдэж ирсэн паспортыг иргэнд олгож байгаа болно.

2022 онд 16, 25, 45 насанд хүрсэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр хамрагдах иргэдэс, иргэний үнэмлэх шинээр авах, дахин авах, сольж авахад бүрдүүлэх материал, иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлнэ зэрэг анонс хийж байгууллагын социал хуудсаар болон цахим хуудсаар түгээж ажиллав.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь хэлтсээс иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын удирдамж, УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэлх хугацаанд тус аймгийн 13 сум, 1 тосгоны нутаг дэвсгэрт хийж гүйцэтгэв. Мөн шалгалт хийх явцад иргэдэд Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлан, таниулан холбогдох мэдээллийг өгч ажиллав.



УБЕГ-ын даргын 2022 оны А/1027 дугаар бүхий тушаалаар Хяналт шалгалтын газраас ирсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020, 2021, 2022 онд хийсэн иргэний улсын бүртгэлийн бүх бүртгэлийг шалгаж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж, ХШГ-ын улсын байцаагчаас ирүүлсэн албан шаардлагыг хуулийн хугацаанд зөрчлийг арилгаж илтгэх хуудас, нотлох баримтийн хамт хүргүүлэн ажилласан болно.

Тус аймагт шинээр олгогдсон хаягийн судалгааг гаргаж бэлдэн аймгийн удирдлагуудад танилцуулан цаашдаа шинэ хаягийг оруулах ажилд хэрхэн хамтран ажиллах талаар төлөвлөгөөндөө тусган ба энэ ажлын хүрээнд Өлгий сумын ИТХ-

аас 2020 онд гарсан багуудын нэршлийг монгол нэршлээр солих тухай тогтоолыг бусад нотлох баримтийн хамт албан бичгээр газарт хүргүүлсэн.

Өнөөдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэлийг 5 хоногийн дотор, эд хөрөнгө өмчлөх эрх, гэрээ хэлцлийг 3 хоногийн дотор, барьцааны гэрээг ажлын 8 цагийн дотор тус тус бүртгэж, улсын бүртгэлийн үйлчилгээний шуурхай байдлыг ханган ажиллаж байна.

Тус аймгийн 5 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна. Өнөөдрийн байдлаар Дэлүүн сумын улсын бүртгэгч С.Рысбай 221, Алтанцөгц сумын улсын бүртгэгч А.Бадамсүрэн 39, Улаанхус сумын улсын бүртгэгч Б.Бахитгүл 91, Алтай сумын улсын бүртгэгч Болормаа 13, Цагааннуур тосгонд Айсауле 31 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг тухайн сумын болон зэргэлдээ сумдад үзүүлсэн байна.

УБЕГ-ын даргын 2022 оны А/427 дугаар тушаалаар батлагдсан “Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-06 маягт”-д өөрчлөлт оруулан, “Барьцааны гэрээ /ипотек/-ний нэмэлт, өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-13 маягт”-ийн заавраар бүртгэж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

УБЕГ-ын ЭХЭУБ-ын газраас ирүүлсэн 2022.11.08-ны өдрийн 6/9582 тоот хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичгээс зөрүүтэй, хуулийн этгээдийг иргэн төлөвтэй, хүчинтэй өмчлөгчийг барьцаалагчаар бүртгэгдсэн 389 бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн засвар өөрчлөлтийг оруулж зөрчлийг арилгасан.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас шүүсэн жагсаалтад тус аймагт харьяалалтай нэгж талбарын дугаар ороогүй бүртгэл байхгүй байна.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас шүүсэн жагсаалтад тус аймагт харьяалалтай эд хөрөнгийн хэмжээ ороогүй бүртгэл байхгүй байна.


- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эд хөрөнгийн үнэ ороогүй газар өмчлөх эрхийн 144, үл хөдлөх эд хөрөнгө 98 бүртгэлийг эх нотлох баримтад үндэслэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 зүгээр зүйлд заасан үнийг улсын бүртгэлийн дугаарын арын мөрөнд бичиж хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын А/424 тоот тушаалаар батлагдсан Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд түдгэлзүүлэх, цуцлах болон түдгэлзүүлсэн, цуцалсныг хүчингүй болгох тухай шийдвэрийн бүртгэл хөтлөх зааврын дагуу /ТБ-01/, /ТБ-02/ маягтуудыг үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна.

УБЕГ-ын 2022 оны 11-р сарын 30-ны өдрийн 6/10321 тоот чиглэлээр хүргүүлсэн Хяналт шалгалтын газраас хийсэн шалгалтаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчлийг арилгах цаашид дахин гаргахгүй байх, дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, бусдын нөлөөнд автахгүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг анхааран ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цаасан суурьт баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг нэвтрүүлэх явцад мэдээллийн санд зөрүүтэй, алдаатай оруулсан эсэх, мөн мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, зөрчил арилгах зорилгоор сар бүр хуваарь гарган хэлтсийн даргаар батлуулан /1 улсын бүртгэгчид сар бүр 100 бүртгэл/ 5000 бүртгэлийн мэдээллийн сантай тулгалт хийн шалгаж, мэдээллийн санд зөрүүтэй, алдаатай гэх 521 бүртгэлийн зөрчлийг бүрэн арилган, бүртгэлийн чанарыг сайжруулан ажилласан болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилтийг цаг алдалгүй хугацаанд биелүүлэн хүргүүлж ажиллав.



Хүснэгт 1. 2022 онд төсөвт оруулсан орлого


Дөрөв. Бүртгэлийн үйл ажиллагаа

4.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар шинээр батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”-уудыг мөрдлөг болгон Иргэний улсын бүртгэлд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 27337 иргэн хамрагдсанаас:

Төрсний бүртгэл 2574, хүүхэд үрчлүүлсний 136, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 38, эцэг, /эх/ тогтоосны 8, гэрлэсний 620, гэрлэлт дуусгавар болсны 51, нас барсны 524, иргэний үнэмлэх олголтын 4474, үндэсний энгийн гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтийн олголт 4821, биеийн давхцахгүй өгөгдлийн 3943, шилжилт хөдөлгөөний бүртгэлд 1130, нэмэлт өөрчлөлтийн

бүртгэлд 1554 иргэн, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээ дахин олголтыг 177, нөхөн бүртгэлд 111 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Нөхөн бүртгэлийн журмаар хамрагдсан 111 бүртгэлийг задалж үзвэл төрсний 24, үрчлэлтийн 2, овог нэр өөрчлөлт 1, нас баралт 2, гэрлэлтийн 82 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Эхний 11 сарын байдлаар 12061 бүртгэлийн 32610 хуудас материалыг цахимжуулсан болно. /хүснэгт 2/



Хүснэгт 2. Иргэний улсын бүртгэлийн тоон мэдээ

Шүүхийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр мэдээллийн санд бүртгэлгүй гэрлэлтийн 18, архивын эх нотлох баримт болон лавлагааг үндэслэн төрөлтийн 24, гэрлэлтийн 64, үрчлэлтийн 2, овог нэр өөрчлөлтийн 1, нас баралтын 2, нийт 93 иргэний мэдээллийг нөхөн бүртгэлийн журмаар бүртгэж маягтуудын “А” талыг УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан байна.

Төрөлт, гэрлэлтийн гэрчилгээгээ гээгдүүлсэн болон гэмтэсэн, засвар өөрчлөлтийн бүртгэлийн дахин олголтоор төрөлтийн 155, гэрлэлтийн 22, нийт 177 иргэнд гэрчилгээ олгов.

Регистрийн дугаар, хүйс зөрүүтэй, шүүхийн шийдвэрээр нас тогтоолгосон, төрсөн, он, сар, өдөр давхцаж олгогдсон, огт бүртгэгдээгүй зэрэг нийт 26 иргэний регистрийн дугаарын бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүртгэл хийв.

Тайлангийн хугацаанд гадаад иргэний гэр бүлийн бүртгэлд нийт 15 иргэн хамрагдсанаас төрсний 13, гэрлэлтийн 2 бүртгэл бүртгэгдсэн байна.

Нийт 9349 лавлагаа олгосон ба иргэнд 7176 лавлагаа, албан хэрэгцээнд 707 лавлагаа, хууль хяналтын байгуулагаад албан тоотоор 1466 лавлагааг тус тус олгосон болно.

Шүүхийн шийдвэр, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, архивын эх нотлох баримт, лавлагааг үндэслэн нөхөн бүртгэлээр 111 бүртгэлийг хийж мэдээллийн санд тусгуулахаар маягтын А талыг ИУБГ-т хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан.

ИУБГ-ын даргын 2022 оын 05 дугаар сарын 18-ний өдрийн 4/4386 тоот албан бичгээр ирсэн чиглэлийн дагуу үндэсний энгийн гадаад паспортын цахимжуулалтын ажлыг 5 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэж хийсэн ба өнөөдрийн


байдлаар 2844 иргэний гадаад паспортын мэдүүлгийг тухай иргэдийн паспорт хэвлэгдэн Е дугаар олгогдож паспорт хэвлэгдэж ирсэний дараа оруулж байгаа болно. Мөн УБЕГ-ын Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргаас 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 10/8406 тоот чиглэлийн дагуу цахимжуулсан хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгаламжийн нэгж болон үдэж цэгцлэн, дагалдах хуудсын хамт архивт улирал тутам өгч байгаа болно.

Иргэд болон сумдын улсын бүртгэгч нараар дамжин ирсэн нэрийн санд хаягийн бүртгэлгүй эцэг эхийн хэн нэгний мэдээлэл дутуу, яс үндэс зөрүүтэй байгаа 528 иргэний мэдээлэлийг хүлээн авч нэмэлт өөрчлөлтийн жагсаалтанд авч 7 хоног болгон албан бичгээр хүргүүлэн мэдээлийн санд тусгуулан зөрчлийг арилгуулсан.

4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулж 2022 оны байдлаар дараах бүртгэлүүдийг хийж гүйцэтгэв. Үүнд:

Тайлангийн хугацаанд үйлчилгээний хураамжийн орлого 60.673.654 төгрөг, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдсанаас оруулсан татварын орлого 233.400.340 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 3.655.903 төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт оруулсан байна.



Хүснэгт 3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Нийтдээ 7872 мэдүүлэг хүлээн авч хянан шийдвэрлэснээс газар өмчлөх эрхийн бүртгэл 3729, газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл 2087, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 4143 тус тус бүртгэж эрхийг нь баталгаажуулсан байна.



Хүснэгт 4. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Тайлангийн хугацаанд нийтдээ 1206 өмчлөх эрх шилжих гэрээ бүртгэж баталгаажуулсан бөгөөд худалдах худалдан авах гэрээ 735, бэлэглэх гэрээ 147, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 175, албадан дуудлага худалдаагаар 1, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 140 бүртгэл бүргэж баталгаажуулсан байна.

Барьцааны гэрээ нийтдээ 4161 барьцааны гэрээ бүртгэсэн ба барьцаалбартай барьцааны гэрээ 653, барьцаалбаргүй барьцааны гэрээ 1237, барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 164, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 209, барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэл 1898 бүртгэж баталгаажуулсан байна.

Тайлангийн хугацаанд 1003 бүртгэлд өөрчлөлт оруулсан бөгөөд үүнээс үрэгдүүлсэн гэрчилгээг нөхөн олгох 19, гэмтээсэн гэрчилгээг дахин олгох 4, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 400, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх бүртгэл 6, өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөгдөх 24, эд хөрөнгийн хэмжээ, үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх бүртгэл 440, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх 103, газар эзэмших эрх газар өмчлөх эрх болж өөрчлөгдөх 7 бүртгэгдсэн байна.

Лавлагаа, хуулбар 133 хийсэн ба 121 хувийн хувийн хэргийг хаасан байна.

Хууль хяналтын байгууллагаас гаргасан албан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх 130 лавлагаа мэдээлэлийг албан тоотоор хүргүүлэн ажиллаж, 5 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, эрх бүхий этгээдийн шийдвэр, хүсэлтийг хувийн хэрэгт нь хавсаргаж цахимжуулсан болно.

Цаашид Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчдийг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, бүртгэлийг үнэн зөв хөтлөх болон цахим системийн боловсруулалтанд анхаарч ажиллах талаар хэлстийн хурлаар анхааруулан ажиллаж байгаа бөгөөд эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой ЭХЭУБГазраас ирсэн чиглэлийг тухай бүр улсын бүртгэгчдэд танилцуулан бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

4.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:


Тус Хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч С.Арман миний бие Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн жинхэнэ албан хаагчийн 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтод заагдсан зорилтуудыг хэрэгжүүлж ажиллахын тулд УБЕХ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хоршооны тухай хууль, Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам, холбогдох бусад хууль, журмыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж дараах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 996 бүртгэл хийсэн болно. Үүнд: шинээр бүртгэсэн ТБАГУТҮГ 6, ХХК 104, НҮТББ 17, Шашны байгууллага 1, Хоршоо 5, Хадгаламж зээлийн хоршоо 1, Салбар 5, Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 547, дахин гэрчилгээ 39, нэрийн баталгаажуулалт 271 /163 нь цахимаар/ болно. Тамга тэмдгийн 191 хяналтын дугаар олгож, ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх хүсэлтээр 55 тэмдэг хурааж авсан. Е-монголиа сайтаар хуулийн этгээдийн нэр болон цахим гэрчилгээ баталгаажуулах нийт 971 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн хариу өгч ажилласан.

Нэт капитал корпораци ББСБ, Мастер шийдэл ХХК, Номин бизнес клуб баруун бүс ХХК, Нэт капитал даблью эс ти ХХК, Монгол улсын Боловсролын Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбаруудыг тус тус зохих журмын дагуу бүртгэж салбарын гэрчилгээ олгож ажилласан.

Хуулийн этгээдийн цахим мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээдэд 69 дүрмийн хуулбар, 71 лавлагаа гаргаж өгч, 7 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч цахим мэдээллийн санд бүртгэсэн болно.

Тайлант хугацаанд шинээр болон нэмэлт өөрчлөлтөөр бүртгэсэн 916 бүртгэлийн бүрдүүлбэр бичиг баримтыг зохих журмын дагуу цахимжуулж архивт хугацаанд нь шилжүүлэн ажиллав.



Хүснэгт 5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа 2 хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхэд хянагдаж буй 4 хэрэгт холбоотой хуулийн этгээдийн талаарх мэдээлэл, нотлох баримтын хуулбарыг зохих журмын дагуу гаргаж өгч ажилласан. Шүүхээр хянагдаж байгаа хэрэг маргааны судалгааг хяналтын улсын байцаагчид гаргаж өгсөн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2022 оны эхний 11 сарын тоон мэдээг хугацаанд үнэн зөв гаргаж, ХЭУБГ-т хүргүүлж ажиллав. 2021 оны эхний 11 сард шинээр 174 хуулийн этгээд бүртгэгдсэн бол 2022 оны мөн үед 132 хуулийн этгээд шинээр бүртгэгдсэнээр шинэ бүртгэл багассан үзүүлэлттэй байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт 2021 оны эхний 11 сард 215 байсан бол 2022 оны мөн үед 547 болж 2,3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл нэмэгдсэн нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн болон хоршооны шинэчилсэн бүртгэлийг эрчимжүүлэн бүртгэсэнтэй холбоотой болно.

Үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр Хэлтсийн нягтлан бодогч, нярав нарт үнэн зөв гаргаж өгч ажиллаж байна.

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацаанд гаргаж удирдлагад танилцуулан ажиллаж байна. ҮАБЗ-ийг мэдээ, мэдээллээр хангах аймгийн ажлын хэсэгт тус аймагт үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн шашны болон төрийн бус байгууллагуудын талаар танилцуулга, холбогдох дэлгэрэнгүй судалгааг журамд заасны дагуу 2 удаа хүргүүлж ажиллав. Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг ХЭУБГ-т хүргүүлж ажиллав.

2022 онд Хэлтэс болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ авахаар ирж буй иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг тухайн өдөрт нь багтаан хүргэж ажилласан.

УБЕГ-аас хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зохион байгуулсан 1 удаагийн танхимын болон 5 удаагийн онлайн сургалтад оролцсон. УБЕГ-ын Хүний нөөцийн нэгдсэн системд байршуулсан Хуулийн этгээдийн хичээлийг бие даан судалж, холбогдох шалгалтыг өгч ажиллаж байна. Сумдын ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан албан хаагч нар болон сумын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон хоршооны шинэчилсэн бүртгэлийн талаар сургалт зохион байгуулж ажиллав. Мөн Терроризмтой тэмцэх зөвлөлөөс зохион байгуулсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон терроризмын аюул занал” сэдэвт цахим сургалтад амжилттай оролцов.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1,2,3 дугаар улирлын тоон мэдээ, эцсийн өмчлөгч, хоршооны шинэчилсэн бүртгэл, санхүүгийн тайлан мэдээгээ 8 улирал дараалан гаргаагүй хуулийн этгээд болон иргэн, хуулийн этгээдүүд хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр цаашид анхаарах асуудлын талаар орон нутгийн радиод 6 удаа ярилцлага өгч ажилласан. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэл, хоршооны шинэчилсэн бүртгэлийн талаарх мэдээллийг фейсбук, социал сүлжээгээр олон нийтэд түгээн ажиллав.


ХЭУБГазар болон Хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд нь биелүүлж тайлагнаж ажиллав. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэл болон Хоршооны шинэчилсэн бүртгэлийн тайлан, судалгааг ХЭУБГ-т хугацаанд нь хүргүүлж ажилласан болно. УБЕГ-ын ХШГ-аас ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу 2022 оны 10 дугаар сарын 01-10 дугаар сарын 31-ний өдөр хийгдсэн хуулийн этгээдийн 54, иргэний улсын бүртгэлийн 156 бүртгэлийн цахимжилтыг шалгаж илтгэх хуудсаар илтгэсэн.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 97 албан тоот, 6 өргөдлийг хүлээн авч хариутай албан тоот, өргөдөлд хугацаанд нь хариу хүргүүлж ажилласан болно.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 18 төрийн байгууллага, албан газарт Гүйцэтгэх удирдлагыг хуулийн дагуу бүртгүүлэх тухай Мэдэгдэх хуудас хүргүүлэн хуулийн хэрэгжилтийг хангуулан ажилласан болно.

Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 3 хуулийн этгээдийн зөрчлийг хэлтсийн хяналтын улсын байцаагчид шилжүүлж дүгнэлтээр, Хяналтын улсын ахлах байцаагчийн 806 дугаар дүгнэлтээр 4 хуулийн этгээдийн зөрчлийг тус тус арилгуулсан. ХЭУБГ-аас ирүүлсэн мэдээлэл нь зөрүүтэй 121 хуулийн этгээдийн мэдээллийг цахим сангаас шалган цахим санд зөвтгүүлэхээр хүргүүлсэн.

Сангийн яамнаас ирүүлсэн 58630 хуулийн этгээдийн жагсаалтыг УБЕГ-аас 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгууллагын цахим хуудсаар олон нийтэд зарласныг татан авч аймгийн радиогоор холбогдох мэдээллийг өгч, фейсбук, социал сүлжээгээр олон нийтэд түгээн ажилласан. Жагсаалтад нэр нь орсон тус аймагт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн судалгааг тусад нь гаргаж холбогдох мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаж байна.



Тайлант хугацаанд эхний хагас жилд хураагдсан 42 тамга, тэмдгийг албан тоот, жагсаалтаар аймгийн Архивын тасагт шилжүүлэн өгсөн болно. Өнөөдрийн байдлаар хураагдаад байгаа 13 тамга, тэмдгийг 12 дугаар сарын сүүлээр шилжүүлэн ажиллах болно.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2-т “Төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа тайланг дараа жилийн 2 дугаар сарын 15-ны дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгнө” гэж заасан байдаг. Гэвч бодит байдал дээр ихэнх төрийн бус байгууллагууд үйл ажиллагааны тайланг ирүүлдэггүй бөгөөд шалтгааныг асууж тодруулахад тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй, гишүүдийн зарим нь нас барсан, өөр газар шилжиж явсан зэрэг тайлбар хэлдэг.

4.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18.7.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх 1 дүгээр зүйлийн 1.4-т заасныг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөхдөө холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, улсын бүртгэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэн, улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг илрүүлэн түүнийг таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулан Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, иргэн хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж, засвар өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийн хангуулж ажиллаж байна.

2022 оны Хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, архивын үйл ажиллагаанд 11 удаа төлөвлөгөөт 7 удаа гүйцэтгэлийн шалгалтыг 26120 бүртгэлд хийсэн байна. Шалгалтын явцад гарсан зөрчлийг таслан зогсоох, арилгуулах арга хэмжээг бүрэн авч 16 албан шаардлага хүргүүлэн зөрчлийг тухай бүр арилгасан.

Иргэдээс улсын бүртгэлийн зөрчил арилгуулах болон хяналтын байцаагчийн дүгнэлт гаруулахаар 181 өргөдөл хүлээн авч 1301 иргэн, хуулийн этгээдэд холбогдох 178 дүгнэлт гаргаж, хууль журмын дагуу хянаж шийдвэр гаргаж, хариу мэдэгдсэн болно. Үүнд: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 124 дүгнэлт гаргаж нийт 1401 иргэний бүртгэлийн зөрчлийг арилгасан, бүртгэлийн үнэн бодит нөхцөл байдлыг тогтоосон байна. Үүнд Бүртгэл хүчингүй болгох тухай 18, иргэний үнэмлэх хүчингүй болгох 90, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 90, регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай 31, Регистрийн дугаар хүчингүй болгох тухай 23, регистрийн дугаар сэргээх тухай 1, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 21 тус тус хянан шийдвэрлэсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс

ирүүлсэн нийт 135 өргөдөл хүсэлтийг хүлээн авсан. Өргөдөл хүсэлтийг хангаагүй буцаасан 25 байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэлийн зөрчлийг арилгах зорилгоор засвар өөрчлөлт оруулах тухай 35, гэрчилгээ хүчингүй болгох бүртгэлд дүгнэлт гаргаж цаг тухай бүр хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Хуулийн этгээдийн улсын 1270 бүртгэлд байнгын хяналт тавьж 540 бүртгэлд шалгалт хийсэн. Хуулийн этгээдийн тамга, тэмдэг хяналтын дугаар хүчингүй болгох тухай 3 дүгнэлт гаргасан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 01-р сарын 28-ны өдрийн 806 дугаартай дүгнэлтээр эх нотлох баримтыг үндэслэн мэдээллийн санд 4 бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулсан, тамга тэмдгийн хяналтын дугаар хүчингүй болгох тухай 2 дүгнэлтийн биелэлтэд хяналт тавьж ажиллав.

Архивын баримтын цахимжуулалтад хяналт тавьж илэрсэн алдааг арилгаж, үнэн зөв цахимжуулах тухай Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан иргэний улсын бүртгэлийн цахим санг цэгцлэх, тулгалт хийх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, зөрчил арилгах арга хэмжээ авч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг өмнө нь буруу цахимжуулсан зөрчлийг арилган цахим санд бүртгэл хийх, бүртгэл хүчингүй болгох, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, зөрчил арилгах зэрэг 5 дүгнэлт гаргаж ажиллав.


Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт нийт 33516 хувийн хэрэг хадгалагдаж байх бөгөөд үүний 15521 нь үл хөдлөх хөрөнгийн, 13394 нь газар, 4877 газар эзэмших эрхийн бүртгэлийн хувийн хэргийг зохих хууль журмын дагуу хадгалагдаж байна.

2022 онд хуулийн этгээдийн бүртгэлийн 81 анхан бүртгэлтийн хувийн хэргийг архивт хүлээж авч улсын бүртгэлийн дараарын дэс дарааллын дагуу байршуулсан болно. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс 230 хувийн хэрэгт баяжилт хийсэн, хураалгаж хүчингүй болсон 15 хуулийн этгээдийн тамга, тэмдгийг усатгалд оруулсан зэрэг ажилд хяналт тавьсан болно.

Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн архивын чиглэлээр нийт 1846 иргэн, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбогдох эх нотлох баримт бүртгэлд хяналт тавьсан байна. Үүнд иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, санал, гомдол, мэдээллийн мөрөөр 1081 улсын бүртгэлийн эх нотлох баримт бүртгэлд, хяналт, шалгалт хийж хууль журмын дагуу 444 бүртгэлд дүгнэлт гаргаж, 638 бүртгэлд тухай бүр шийдвэр гаргаж хариу өгч, архивт хадгалагдаж буй эх нотлох баримт, бүртгэлийг газар дээр нь хянаж улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн чиглэл өгч ажилласан байна.

Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, тогтоосон хууль, журам зөрчсөн, үндэсний энгийн гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх үрэгдүүлсэн, гэмтээсэн, иргэний үнэмлэх болон үндэсний энгийн гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, ашиглах, хадгалах, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам зөрчсөн, үнэн зөв мэдүүлээгүй, тамга, тэмдэг үйлдвэрлэх, хэрэглэх, хадгалах журам зөрчсөн үндэслэлээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д “улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 2, 6, 7 ,

10.20 дугаар зүйлийн 1, 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 15.23 дугаар зүйлийн 1.1, 15.24 дүгээр зүйлийн 1, 2, 4 дэх хэсэгт заасан зөрчлийг гаргаж зөрчсөн 188 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэн төсөвт нийт 6 665 000 төгрөг оруулсан байна. Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 50 хувь буурсан үзүүлэлттэй байна. Хуулийн дагуу 1 зөрчлийн хэрэг шалгаж шийдвэрлэсэн болно. Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах тогтоол 8, гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэсэн 3 гаргасан болно.



Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

2022 оны байдлаар иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн чиглэлээр ИУБ-11 төрөлт-2720, ИУБ-12 үрчлэлт-149, ИУБ-13 овог эцэг-эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-50, ИУБ-14 эцэг тогтоолт- 10, ИУБ-15 гэрлэлтийн бүртгэл-686, ИУБ-16 гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-46, ИУБ-18 нас баралт-524, аймаг нийслэл рүү шилжин ирсэн-436, ИБЗ-1 мэдээлийн санд нөхөн бүртгэлд оруулах-135, ИУБ-31 Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-3030 буюу нийт 8650 маягтуудыг журмын дагуу хүлээн авч баримтыг хувийн хэрэгт баяжилт хийсэн болно. Иргэний 8-н төрлийн бүрдүүлбэр, гадаад паспорт мэдүүлэг 218 гаруй хадгаламж нэгж хүлээн авсан болно.

Тайлант хугацаанд хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн 771 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд гарган өгч, ирсэн албан бичгийн дагуу 1466 лавлагаа, 656 холбогдох нотлох маягтуудыг хуулбарлан хүргүүлэв.

Регистрийн дугаар буруу, хүйс зөрүүтэй, ИУБ маягт нөхүүлэх МҮ-санд ороогүй, нас тогтоолгох, төрөлт тогтоох, нас баралт тогтоох, шүүхийн журмаар гэрлэлт цуцлалтын бүртгэлийн зөрчлийг арилгахын тулд нийт 489 иргэний хувийн хэргийг Архивын фондоос захиалгын хуудсаар бүртгэл хөтөлж Улсын бүртгэгч, Хяналтын улсын байцаагч нарт гаргаж өгөх хүлээн авч буцаан байрлуулан ажиллав.

Хадгалах нэгжийн хугацаа дууссан бичиг баримтын тоог гарган УБЕГ-ын бичиг баримт нягтлан шалгах ажлын комисст хүргүүлэн, устгах баримт бичгийн жагсаалт ирүүлсэний дараа маягт болон дагалдах хуудасуудыг устгалд оруулсан.

Тайлант жилийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт нийт 1233 хувийн хэргийг шинээр архивт хүлээж авч шинээр нээсэн хувийн хэрэг бүртгэх маягт дэвтэрт бүртгэж улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу хаяглаж архивт байршуулсан болно.



Үүнд: газар өмчлөлийн анхны бүртгэл 634, газар эзэмших 4877, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн анхны бүртгэл 599, ашиглах эрхийн 2 хувийн хэрэг орсон байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар бүртгэл нь хүчингүй болж хаагдсан 121 хувийн хэрэг байна.

Мөн улсын бүртгэгч нарын өдөр тутам хүлээж авсан нэмэлт өөрчлөлт, худалдах худалдан авах гэрээ, бэлэглэх гэрээ, өв залгамжлах гэрээ, барьцааны гэрээ, лавлагаа, хуулбар зэрэг нийт 7078 гаруй нотлох баримтуудыг архивт хүлээж авч хувийн хэргийн байжилтыг цаг тухайд нь хийж байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 33516 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүний: 15521 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, 13398 нь газар өмчлөл, үлдсэн 4877 газар эзэмших эрхийн бүртгэл, 6 нь ашиглах эрхийн бүртгэлийн хувийн хэрэг байна.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлийн 132 анхны бүртгэлийн хувийн хэргийг архивт хүлээж авч улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу байршуулсан болно. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчид бүтэн жилийн хугацаанд 691 гаруй хувийн хэргийн баяжилтыг хүлээн авч цаг тухайд нь зохих журамын дагуу байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт 2400 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хураагдаж хүчингүй болсон 15 хуулийн этгээдийн хуучирч гэмтсэн тамга тэмдгийг журмын дагуу устгалд оруулсан болно.



Зургаа. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд

Хэлтсийн үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж ирсэн ба санал хүсэлт, мэдээллийг төрөлжүүлэн дүгнэж, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж байна. Өдөр тутмын үйл ажиллагаа болон улсын бүртгэлийн үйлчилгээ, зан харилцааны асуудлаарх иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийг тухай бүр хэлтсийн дарга биечлэн хүлээн авч шийдвэрлэн, иргэдэд ойлгомжгүй байгаа асуудлыг Тасгийн дарга нараар тайлбарлуулан иргэдэд үйлчилж байна.

Авлига, ашиг сонирхол зөрчлийн талаар мэдээлэл ирээгүй байна. Албан хэрэг хөтлөлтийн АВЛЕ програмд ирсэн, явсан бичиг болон өргөдөл, гомдлыг бүрэн цахимжуулан оруулж ажиллаж байна.

ХЗДХЯ-наас 2022 оны 3/5952 дугаар албан бичгээр "ХЗДХЯ-ны салбарын цахим архив, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем"-ийн нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд E-DOC системийн сургалтад хамрагдаж, 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэглээндээ нэвтрүүлэн АВЛЕ системтэй давхар ашиглаж эхлэсэн болно.

Тайлангийн хугацаанд /2022.12.02-ны өдрийн байдлаар/ хууль хяналтын болон бусад байгууллагуудаас 1245 албан бичиг хүлээн авсан байх ба нийтдээ 1537 албан бичиг гадагш явуулсны 1022 нь хууль, хяналтын байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичиг болно.

Мөн хэлтсийн даргын "А" тушаал 5, "Б" тушаал 13, нийт 18 тушаалыг гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Оны эхнээс /2022.12.02/ иргэдээс нийт 317 өргөдөл хүлээн авч, холбогдох албан хаагч бүрт танилцуулан хувиарлан хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлсэн.

Үүнээс: Захиргаа удирдлагад /хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, эд материал, санхүүгийн дэмжлэг, албан хаагчдын чөлөө хүсэх, талархал г.м/ 19 өргөдөл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 8, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 6 өргөдөл ирсэн байх ба Иргэний бүртгэл болон Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргахтай холбоотой /үрчлэлт, төрөлт, нас баралт, гэрлэлт, гэрлэлт дуусгавар болсоныг бүртгүүлэх мөн регистрийн дугаар зөвөтгөх, гэрчилгээ дахин олгох, тодорхойлолт, лавлагаа олгох/ 284 байна.

2021 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар нийт 317 иргэний өргөдлөөс 309 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад шилжүүлсэн 0, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 0, хугацаа болоогүй 8 иргэний өргөдөл хяналтад байна. Мөн шийдвэрлэлтийн хувь 97.5%-тай байна.

Иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилвал иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний баримт бичгийн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байгаа ба иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байгаа болно. Мөн иргэдийн өргөдөл, гомдлыг Хэлтсийн 70427810, 70427766 дугаарын утсаар авч ажиллаж байна.


2022 оны 11 сарын байдлаар хэлтсийн үйл ажиллагааны явцад албан хэрэг хөтлөлтийн байнга хадгалах баримт 24 хадгаламжийн нэгж үүсгэж архивласан.

Өргөдөл гомдлын мэдээг загвар хүснэгт дагуу гаргаж, улирлын сүүлийн сарын 15-ны дотор УБЕГ-ын Тамгын газрын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнд баталгаажуулан хүргүүлж байна.

Мөн хэлтсийн цахим хуудасны өргөдөл, гомдлын цонхонд тогтмол байршуулж байгаа болно.

Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаарх албан даалгаврыг ажилтнууддаа танилцуулан, хэлтсийн ажилтнуудын цагийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулан, өглөө болгон цагийн бүртгэлтэй танилцаж, чиглэл өгч ажилласан. Сумдын анхан шатны бүртгэгчдийн цаг ашиглалтын байдалд сумын Засаг даргын тамгын газартай хамтран хяналт тавин ажиллаж байна.

Өргөдөл, гомдлын тоон үзүүлэлт графикаар:



Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан / Мэдээллийн технологи, программ хангамжийн хүрээнд /

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлогын баримт бичиг”, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.


Тус хэлтсийн цахим хуудас нь <https://bayan-ulqii.burtgel.gov.mn/> гэсэн хаягтай. Тайлант хугацаанд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэл, бүртгэлийн үйл ажиллагааг тус цахим хуудсанд 124 мэдээлэл байршуулсан ба олон нийтэд түгээх зорилгоор мэдээллийг фото зургийн хамт олон нийтийн социал сүлжээ буюу <https://www.facebook.com/bayanulqii.burtgel> фэйсбук пэйж хуудсаар мэдээллийг давхар түгээж ажилласан байна. Үүнээс гадна УБЕГ-аас гаргасан аливаа шторк, мэдээллүүд, цахимаар бүртгэлийн үйлчилгээ авах зэрэг мэдээллийг тухай бүр байршуулан шэйр хийж байна. Өнөөдрийн байдлаар 3300 дагагчтай болсон байна. 2022 онд социал хуудсаар дамжуулан 181 бүртгэлтэй холбоотой мэдээлэл түгээсэн байна.

Цахим хуудасны танилцуулга цонхонд нэгжийн бүтэц, албан хаагчдын мэдээлэл, ил тод цонхонд хүний нөөцийн ил тод байдал, шилэн данс, хурал, сургалт, семинарын зар, улирал, жилийн тайлан, хэрэглэгч танд цонхонд түгээмэл асуулт хариулт, нээлттэй ажлын байрны зар, өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал, сар бүрийн тоон мэдээ, холбоо барих цонхонд байгууллагын хаяг, байршил, ажиллах цагийн хуваарь, иргэдийг хүлээн авах цаг, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах утасны дугаар, шуудан хаяг зэргийг нээлттэй байршуулсан

болно. <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/sar-buriin-toon-medeelel>

Нүүр хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл, видео мэдээллүүд, аймгийн танилцуулга, түүх болон дурсгалт газрууд, фото зургийн цомог, мөн аймгийн далбаа, газрын зургийг бүрэн оруулсан. Баннер хэсэгт төрийн үйлчилгээний E-mongolia цахим систем, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ авах Burtgel.mn систем, хуулийн этгээдийн оноосон нэр олголтын систем, авлигыг мэдээлэх 110 утас болон бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 зэрэг баннерүүдийг байршуулсан.

Цахим хуудасны хөл хэсэгт бусад аймгуудын холбоос болон хэлтсийн Google тар дахь газрын байршилыг харуулсан болно.



Тус хэлтэс нь батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 оны эхний 12 сарын байдлаар улсын төсвөөс 477.877.500 төгрөг, нэмэлт санхүүжилтээр аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 4.918.0000 төгрөг, нийт 482,795,500 төгрөгийн санхүүжилт авснаас 478.784.642 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ба энэ нь нийт төсвийн 99.1% байна. Мөн тайлант хугацаанд 192.500.000 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байсанаас 134.779.038 төгрөгийн орлого оруулж, Сангийн Яам Улсын Төсөвт 132.398.039 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн болно. Орлогын төлөвлөгөөг 70%-иар биелүүлсэн байна. Сар бүрийн 2-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн тайлан ба өглөг авлага, нэр данс зөрүүгийн тайлан, санхүүгийн сарын мэдээг УБЕГ-т хүргүүлж ажиллаж байна. Үнэт цаасны зарцуулалтын тайлан болон үлдэгдлийн тайлан, иргэний үнэмлэхийн орлогын тайланг хугацаанд нь дээд газарт хүргүүлж байна. Одоогийн байдлаар тус хэлтэс нь ямар нэгэн өр авлагагүйгээр ажиллаж байгаа болно. Мөн түүнчлэн ХАОАТ болон НДШ-ийн тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хуулийн хугацаандаа хүргүүлсэн. Хэлтсийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгүүлж “Зөрчилгүй” дүгнэлт авсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүд болох тухай бүр оруулах 88, сар бүр оруулах 33, улирал бүр оруулах 3, хагас жилээр оруулах 4, бүтэн жилээр оруулах 5 мэдээллүүдийг хуульд заасан хугацаанд нь оруулж ажиллаж байна. Үнэт цаасны тооцоог сар болгон албан хаагч бүртэй хийж, үлдэгдэл үнэт цаасыг тулган ажилласан.

Хэлтсийн төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар болон

цахим хуудаст 2022 оны төсөв болон сар бүрийн орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтийн 1-11 дугаар сарын мэдээнүүдийг байршуулсан. Мөн 2023 оны төсөв 2024-2026 оны төсвийн төсөөлөл, Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг хамаарч тооллого явуулсан ба өмч хөрөнгүүдийг программд нэг бүрчилэн шивж, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2021 оны биелэлтийг хүргүүлж, 91 хувиар дүнг баталгаажуулан дүгнүүлэн ажиллав. Санхүүгийн тайланг улирал, хагас жилээр гарган холбогдох газарт хүргүүлсэн. 11 сарын байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газраас 21.360.500 төгрөгийн үнэт цаас бараа материал, 19.238.846 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан болно. Хэлтсийн эд хөрөнгийн тооллогыг хэлтсийн даргын тушаалын дагуу хуулийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Найм. Сургалт, үйл ажиллагаа тайлагнах ажлын хүрээнд

Улсын бүртгэлийн ерөнхий газар, төрийн албаны зөвлөл, Бусад хууль хяналтын байгууллагуудтай хамтарсан зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар нийт 55 удаагийн сургалтад давтагдсан байдлаар 884 албан хаагч хамрагдсан байна. Хэлтсийн 2022 оны сургалтын төлөвлөгөө боловсруулж, баталуулан, төлөвлөгөөний дагуу улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурталчилах зорилгоор нийт 12 сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд 7 дотоодтой, 5 бусад байгууллага, албан тушаалтан нартай хамтран зохион байгуулав. Хүний нөөцийн сургалтын системийн Бие даан хийх хичээлийн хэсгийг улсын бүртгэгч нарт судлуулан шалгалтыг нь өгч ажилласан болно.

Дотооддоо дараах сургалтуудыг зохион байгуулав.

- Авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газартай хамтран 150 гаруй албан хаагч нарт “Хүний эрх, төрийн албан хаагчийн эрх, үүрэг хариуцлага” сэдэвт сургалт
- E-mongolia цахим хуудаснаас улсын бүртгэлийн үйлчилгээг авахад иргэдэд дэмжлэг үзүүлэх, зааварчилгаа өгөх /Ховд Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн багш, оюутнууд/
- 13 сум, 1 тосгоны шинээр томилогдсон багийн Засаг дарга нарт Улсын бүртгэлийн ерөнхий хууль, бусад хууль эрх зүйн актын хүрээнд анхаарах асуудлуудын талаар зөвлөмж чиглэл өгөх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааг сайжруулах
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон жендэрийн тухай ойлголт
- Гамшгаас хамгаалах арга хэмжээ, галын аюулгүй байдлыг хангах, галын аюулгүй байдлыг хангах, галын аюулаас урьдчилан сэргийлэх
- Төрийн албан хаагчийн ёс зүйн ба улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт
- Улсын бүртгэлийн байгууллагын хууль тогтоомж болон холбогдох бусад хуулийн талаар ойлголт



Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлж байгаа “Цахим Үндэстэн” дунд хугацааны бодлогын баримт бичгийг хангахын тулд төрийн албанд ажиллаж байгаа мэдээллийн технологийн мэргэжилтэнүүдийг мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр чадавхжуулах сургалтад тус хэлтсийн Мэдээллийн технологийн ажилтан хамрагдаж Сертификат авсан болно.

Удирдах ажилтанд жендэрийн талаарх үндсэн ойлголт, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалтай танилцаж, байгууллага, хамт олноо жендэрийн мэдрэмжтэй удирдан манлайлах, жендэрийн асуудлыг бодлого, төлөвлөгөөнд тусган шийдвэр гаргаж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд мэдээлэл өгөх зорилго бүхий Жендэрийн үндэсний хорооны “Төрийн албаны удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалт”-д хэлтсийн дарга хамрагдаж Ж1 Сертификат авсан болно.



Төрийн удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хэлтсийн дарга Х.Амангүл хамрагдаж төгссөн ба Хяналтын улсын байцаагч А.Еркегүл суралцаж байна. Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Д.Аманбек НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр Сонгуулийн Ерөнхий хороотой хамтран хэрэгжүүлж буй “Хариуцлагатай сонгогч” сургалтын хөтөлбөрийн хамрагдаж сургагч багшийн сургалтад хамрагдаж Гэрчилгээ авсан болно. ЭХЭУБ-ийн тасгийн улсын бүртгэгч Х.Тилеубек Удирдлагын академийн Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг богино хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж байна.



Мөн хэлтсийн дарга Х.Амангүл Төрийн худалдаан авах ажиллагааны газрын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдаж Гэрчилгээ авсан болно.

Тайлагнасан ажлууд

- Төрийн захиргааны албан хаагчийн 2021 оны ХАСХОМ-ын нэгдсэн тайлан
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Хүний эрх, хүн худалдаалахтай тэмцэх
- Терроризмоос урьдчилан сэргийлэх
- Жендэрийн тэгш байдлыг хангах ажлын төлөвлөгөөний биелэлт
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Монгол бичгийн тайлан
- Мэдээллийн ил тод байдлын тайлан
- Мэдээллийн самбар байршуулсан талаарх тайлан
- Инфографик мэдээллийг байршуулсан талаарх тайлан
- Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн дэлгэрэнгүй мэдээ
- Гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаас, маягтын сар бүрийн зарцуулалтын тайлан
- Төсвийн гүйцэтгэл, үйлчилгээний орлогын тайлан
- Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх сар бүрийн тоон мэдээг УБЕГ-т хүргүүлж ба хэлтсийн цахим хуудасны тоон мэдээ цонхонд тогтмол байршуулан ажиллаж байна.

Ес. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд

Цахим гарын үсгийн тухай хууль эцэслэн батлагдаж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуульд зааснаар Улсын бүртгэлийн байгууллага нь гэрчилгээжүүлэх байгууллага бөгөөд Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг олгохоор тусгагдсан.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагаас тоон гарын үсгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн иргэдэд олгож эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар тус хэлтсээс 19,212 иргэн тоон гарын үсгээ авсан байна.

Энэ нь Баян-Өлгий аймгийн 16-аас дээш насны нийт иргэдийн 27 хувьд олгосон байна.

Нэгжийн нэр	2022/ 05 сар	2022/ 06 сар	2022/ 07 сар	2022/ 08 сар	2022/ 09 сар	2022/ 10 сар	2022/ 11 сар	2022/ 12 сар	Нийт тоо
Баян-Өлгий хэлтэс	889	115	17	78	663	715	227	14	2718
Баян-Өлгий, Баяннуур	531	510	65	35	58	153	269	78	1699
Баян-Өлгий, Алтанцөгц	197	121	26	2	194	365	197	8	1110
Баян-Өлгий, Ногооннуур	79	104	4	26	171	196	102	10	692
Баян-Өлгий, Алтай	188	142	27	10	130	131	113	68	809
Баян-Өлгий, Цэнгэл	256	64	14	18	111	908	519	33	1923
Баян-Өлгий, Дэлүүн	151	119	30	33	42	333	839	61	1608
Баян-Өлгий, Толбо	147	260	26	71	177	439	406	18	1544
Баян-Өлгий, Буянт	404	104	54	85	367	428	55	4	1501
Баян-Өлгий, Улаанхус	158	15	5	4	126	694	425	4	1431
Баян-Өлгий, Цагааннуур	153	48	21	27	32	140	56	5	482
Баян-Өлгий, Булган	74	13	0	0	52	173	94	0	406

Баян-Өлгий, Өлгий	270	194	46	15	112	451	364	5	1457
Баян-Өлгий, Сагсай	157	53	12	21	48	323	112	17	743
Баян-Өлгий, Бугат	29	232	14	13	289	275	188	49	1089
Нийт тоо	3683	2094	361	438	2572	5724	3966	374	19212

Хүснэгт 8. Нэгжүүдийн тоон гарын үсэг олголтын тоон мэдээ

Тоон гарын үсэг олголтыг УБЕГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу эрчимжүүлэх ажлын хүрээнд бүх албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд албан бичиг хүргүүлэн, радио, телевизд ярилцлага өгч, томоохон аж ахуй нэгж албан байгууллагуудад очиж тоон гарын үсэг олгох, сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласан.

Нээлтийн ажиллагааны үеэр аймгийн Засаг дарга ирж оролцон хамт олноороо нэгдэн тоон гарын үсэг авах уриалгыг олон нийтийн сүлжээгээр лайв хийж сурталчилан ажилласан.




Нэгж: Баян-Өлгий - 830000. Хамааралтай нэгжийн тоо: 14									
Огноо	Иргэний үнэмлэх	Мобайл апп	Эрэгтэй	Эмэгтэй	0 - 24 хүртэлх	25 - 44 нас	45 - 60 нас	60 - с дээш	Нийт
2022 оны 5 сар	3,683	0	1,913	1,770	287	1,974	1,159	263	3,683
2022 оны 6 сар	2,094	0	954	1,140	291	987	638	178	2,094
2022 оны 7 сар	361	0	181	180	60	149	119	33	361
2022 оны 8 сар	419	19	214	224	99	197	119	23	438
2022 оны 9 сар	2,279	293	1,060	1,512	361	1,356	740	115	2,572
2022 оны 10 сар	5,468	256	2,780	2,944	952	2,815	1,523	434	5,724
2022 оны 11 сар	3,910	56	2,060	1,906	646	1,761	1,157	402	3,966
2022 оны 12 сар	367	7	190	184	37	146	130	61	374
Нийт	18,581	631	9,352	9,860	2,733	9,385	5,585	1,509	19,212

Хүснэгт 9. Тоон гарын үсэг олголтын төрөл, насны ангилал

Тоон гарын үсгийг 9-р сараас эхлэн иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд олгохоос гадна ухаалаг гар утасны аппликэйшнээр дамжуулан олгож эхэлсэн. Тоон мэдээнээс харахад 631 иргэнд гар утасны Gsign аппликэйшнд тоон гарын үсэг авсан байна.




Тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдол, олголтын талаарх УБЕГ-аас бэлтгэсэн видео шторкууд, цахим мэдээллүүдийн тухай бүр хэлтсийн цахим хуудас, олон нийтийн сүлжээний фэйсбук пэйж хуудас, орон нутгийн телевизүүдээр цацаж олон нийтэд түгээж ажилласан.



Олны танил, олон нийтийн сүлжээнд олон дагагчтай алдартай хүмүүст тоон гарын үсэг олгож олон нийтэд сурталчлах үүрэг даалгаврын хүрээнд Авьяаслаг Монголчууд шоуны шилдэг оролцогч МУСТА ая зохиогч, дуучин Д.Бердибек,

Бүргэдчин охин Айшолпан нарыг хэлтэс урьж тоон гарын олгож, “Тоон гарын үсэг авцгая” уриалга шторкийг өөрийнхөө фэйсбук хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн ажилласан.

Мөн мэдээллийн МОНЦАМЭ агентлагт Тоон гарын үсгийн олголтын талаарх мэдээг нийтлүүлэх зэрэг сурталчилах ажлуудыг зохион байгуулсан.



Аймгийн алслагдсан багуудад очиж бүртгэлийн үйлчилгээ, тоон гарын үсэг олгох хүндрэлтэй байсан учраас УБЕГ-ын МТГ-т хүсэлт хүргүүлэн Улсын бүртгэлийн сүлжээг дамжуулагч 4G төхөөрөмж шийдвэрлүүлэн авснаар Өлгий сумын 7-р баг буюу Хотгор уурхай, Улаанхус сумын Хөх хөтөл баг, Сагсай сумын Даян баг зэрэг алслагдсан багийн иргэдэд бүртгэлийн үйлчилгээ, тоон гарын олгож хүрч ажилласан болно.

Арав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/

Аймгийн ЗДТГ, болон бусад төрийн байгууллагатай хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажилласан ба төрийн болон хууль хяналтын байгууллагад лавлагаа мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн ИТХ, Засаг даргад тус хэлтэст тулгамдаж байгаа асуудлуудын талаар санал хүргүүлж

- хэлтсийн байранд орчин үеийн чанарын шаардлага хангасан хяналтын камер 4.800.000 төгрөг
- Тоног, төхөөрөмж худалдан авах 10.000.000 төгрөг
- орон нутагт үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажилагааг бэхжүүлэх зорилгоор нууцын зэрэглэлийн баримт бичиг хадгалах сейф 1.550.000 төгрөг
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс орон нутагт томилогдон ажиллаж байгаа албан хаагчийн амьдрах байрны түрээсийн зардал 4.600.000 төгрөг

“Цахим засаглал” хөтөлбөр, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай цахимаар хүргэх ажлын хүрээнд сумдын Засаг дарга, удирдлага нартай хамтран ажиллаж, санал хүргүүлснээр орон нутгийн хөгжүүлэх сангаас

- Өлгий сум Улсын бүртгэлийн КИОСК машин 23.000.000 төгрөг
- Цэнгэл сум Улсын бүртгэлийн КИОСК машин 23.000.000 төгрөг
- Дэлүүн сум цахим төлбөрийн Гэрэгэ Киоск машин 7.000.000 төгрөг

- Улаанхус сум цахим төлбөрийн Гэрэгэ Киоск машин 7.000.000 төгрөг
- Буянт сум цахим төлбөрийн Гэрэгэ Киоск машин 5.000.000 төгрөг
- Ногооннуур сум цахим төлбөрийн Гэрэгэ Киоск машин 3.000.000 төгрөг
- Буянт сум тог баригч 250.000 төгрөг
- Бугат сум тог баригч 250.000 төгрөг
- Сагсай сум тог баригч 250.000 төгрөг

Нийт орон нутгийн төсвөөс 89.700.000 /наян ёсөн сая долоон зуун мянган/ төгрөгийг шийдвэрлүүлсэн байна. Тайлангийн идэвх санаачлага хэсэгт дэлгэрэнгүй оруулсан болно.

Аймгийн Засаг дарга Д.Бауыржанаар ахлуулсан баг өвөлжилтийн нөхцөл байдал болон төрийн үйлчилгээний хүртээмжтэй танилцах зорилгоор сумдад ажиллаж, ажлын хэсэгт тус хэлтэсийн дарга, хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нарыг хувиарлан оролцуулж ажилласан болно.



“Хуульчийн про боно өдөр”, “И-Монгол” академийн баг Баян-Өлгий аймагт ажиллах үеэр аймгийн төв талбайд НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ зохион байгуулагдаж уг арга хэмжээнд тус хэлтсийн холбогдох албан хаагчид оролцож Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээ, лавлагаа мэдээллийг цахимаар авах, тоон гарын үсгийн хэрэглээний талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.



Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг олон нийтэд таниулах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тогмтол ярилцлага өгч, албан байгууллагуудад мэдээллийн цаг, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, сумдын улсын бүртгэгч нар БИНХ-д оролцож мэдээлэл өгч ажиллав.



Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нутгийн төрийн захиргааны байгууллагын

хууль тогтоомжийг Орон нутгийн Саян, Дербес телевиз, олон нийтийн радиогоор сурталчлах баталсан график төлөвөлгөөний дагуу иргэдэд мэдээ мэдээлэл 12 удаа ярилцлага өгсөн болно.

Байгуулагдсанаас хойш ямар нэгэн нэмэлт өөрчлөлт хийлгээгүй 292 хуулийн этгээдийн судалгааг гаргаж аймгийн Татварын хэлтэст хүргүүлж татварын нэгдсэн сантай тулгалт хийж ажилласан. Тулгалтын явцад 32 хуулийн этгээд татварын баазад бүртгэлгүй, татвар төлдөггүй гэсэн дүн гарч байна.

2022 оны 4 дүгээр сарын 7-8-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Хоршооны бүртгэлийн асуудлаарх сургалтад хамрагдаж, зохих мэдээ мэдээллийг авсны үндсэн дээр тус аймагт үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн 309 хоршоонд зар хүргүүлж, Шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. 2022 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 66 хоршоог ШБ-д хамруулан ажилласан байна.



Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөл Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулсан ба тус шалгалтад орохоор бүртгүүлсэн иргэдийг Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлээр /хуруу хээ/ таниулан шалгалт өгөх эрхийг баталгаажуулан хамтран ажилласан болно.

Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан Тангараг өргөх ёслолд тус хэлтсийн төрийн жинхэнэ албанд анх орж, тусгай шалгалт өгч томилогдсон Иргэний бүртгэлийн улсын бүртгэгч А.Алтангул, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч Д.Нина, Буянт сумын улсын бүртгэгч С.Жаргалсайхан, Ногооннуур сумын улсын бүртгэгч Б.Жанар нарыг хамруулж, төрийн албан хаагчийн тангараг өргөсөн.



Төрийн албаны шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн төрийн байгууллагын хүний нөөцийн аудит хийх ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу тус хэлтэс дээр ажиллах үеэр холбогдох мэдээллээр ханган ажиллав.

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Консулын хэлтсийн дэд дарга Антони Мотиси, консулын хэлтсийн ажилтан Б.Уянга, Б.Лхагважаргал нар Улсын бүртгэлийн хэлтсийн удирдлагуудтай уулзалт

хийж, бүртгэлийн ажилтнуудад хуурамч паспорт хэрхэн таних, иргэний бичиг баримтын талаарх мэдээлэл хийв.



Улсын бүртгэлийн байгууллага нь цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд барьцааны гэрээ, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, барьцааны гэрээг дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх, эрхийн улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг хөнгөн шуурхай, хялбар болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкууд, ББСБ, ХЗХоршооны төлөөллүүдтэй Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд орж буй өөрчлөлтүүдтэй холбоотой харилцан мэдээлэл солилцох, уялдаа холбоо сайжруулах, нэгдмэл нэг ойлголттой байх, харилцан тохиролцож ажиллав.



Аймгийн Засаг даргын Тамгын газраас “НАУРЫЗ” баярыг угтан зохион байгуулсан төрийн байгууллагуудын “Ажилтан, албан хаагчид үндэсний хувцсыг сурталчлах” уралдаан, “Наурыз”-ын баярын өдрийн парадад "ХҮҮХЭД ӨЛГИЙДЭХ" зан заншилыг ёслол төгөлдөр үзүүлэн оролцов.



Газрын харилцаа, хот байгуулалтын газрын удирдлагуудтай төрийн албаны уялдаа холбоог сайжруулах, иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээнд салбар дундын хууль эрх зүйд холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангаж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх хамтарсан ажил хэргийн уулзалт зохион байгуулав.

Сар бүрийн 3-ны өдөр цусаа бэлэглэх өдөр болгон зарласны дагуу аймгийн цусны төвтэй хамтран 2 удаа албан хаагчид цусаа хандивлав. Тус хэлтсийн Улсын ахлах бүртгэгч Д. Аманбек, Улсын бүртгэгч М.Роза, Ахлах нягтлан бодогч А. Ертауке нар тогтмол цусаа бэлэглэдэг донор ажилчид болно.

"Жендэрийн Үндэсний Хороо"-ноос 2022 оны 03 сарын 01-ний өдрөөс 04 сарын 01-ний өдрийг хүртэл нэг сарын хугацаатай зохион байгуулсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилготой ОУ-ын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах өдөр, Монгол Цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ" аян, "ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ ӨЛГИЙЧҮҮД АЯН"-д тус тус нэгдэн оролцсон.



Монгол улсын Шадар Сайд аймгийн Засаг даргатай байгуулсан Монгол улсын Засгийн газрын зарчим, чиг үүргийг Баян-Өлгий аймагт төлөөлөн хэрэгжүүлэх, гэрээний 3 дугаар заалтын 3.6 дахь хэсэгт болон аймгийн Засаг даргын 2022 оны

А/190 дүгээр захирамжийн дагуу 4 дүгээр сарын 11,12-ний өдрүүдэд Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулагдав.

Гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуульд Улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн амжилттай оролцож гамшгаас хамгаалах сургуулилт, бэлэн байдлын чадвараа дээшлүүлэв.



Тус сургуулийн үеэр “Гамшиг, онцгой нөхцөл байдал, аюулт үзэгдэл, ослын үеийн орон нутгийн удирдлагын шийдвэр гаргалт, зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн харилцан ажиллагаа” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан хээрийн бие бялдарын сорил арга хэмжээнд тус хэлтсийн мэргэжлийн ангийн ахлагч Ш.Еркинбек оролцож 1-р байр эзэлсэн.

Залуу үеийнхэнд эх оронч сэтгэлгээг бий болгох, шударга амьдарч, хөдөлмөрлөж, төр түмнээ эрхэмлэн дээдлэн, түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилготой “Монгол Улсын Иргэний Андгай Өргөх Ёслол”-ыг 2022 оны 11 сарын 25-нд Аймгийн ЗДТГ-ын Хурлын зааланд ёслол төгөлдөр хийлээ.

Монголын бахархлын өдөр буюу Их Эзэн Чингис Хааны мэндэлсэн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 20 дахь жилдээ зохион байгуулж уг үйл ажиллагаанд тус аймгийн сургуулиудын төлөөлөл болсон 25 сурагч оролцсон юм.

Үйл ажиллагаанд аймгийн ТЗУХ-ийн дарга Д.Ербол, ГБХЗХГ-ын дарга Х.Пернгул, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Х.Амангүл нар оролцож 16 настнууддаа хандан чин сэтгэлийн үгээ хэлж, баяр хүргэн иргэний үнэмлэх, батламжийн ёслол төгөлдөр ажлыг хийж гүйцэтгэсэн болно.




Арван нэг. Идэвх санаачлага, шинэлэг ажил

Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2022 онд тус аймгийн эхлэн Дэлүүн, Улаанхус, Алтанцөгц, Алтай сум, Цагааннуур тосгоноос үзүүлж байна.

Энэ хүрээнд тус сумын болон зэргэлдээ сумын иргэн, аж ахуйн нэгжүүд аймгийн төвийг зорин ирэх шаардлагагүй болж цаг хугацаа хэмнэн бүртгэлээ сумаас авах бүрэн боломжтой болсон.



Сумдад шинээр томилогдсон багийн Засаг дарга нартай уулзаж, Улсын бүртгэлийн талаар ерөнхий ойлголт, мэдээ мэдээлэл өгч, иргэдээ хуулийн хугацаанд Улсын бүртгэлд хамруулах талаар хамтран ажиллав. 2022 онд 16 насанд хүрч биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр бүртгүүлж иргэний үнэмлэх анх удаа авах, 25, 45 насны иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацааны сунгалт хийлгэх иргэдийн судалгааг сумын хэмжээнд баг тус бүрээр нь гаргаж, багийн Засаг дарга нарт хүлээлгэн өгч тухай бүр мэдэгдэж, урилга өгч, иргэдийг хуулийн дагуу тогтоосон хугацаандаа бүртгэлд хамрагдахыг зөвлөж, сургалт сурталчилгаа тогтмол хийж ажиллаж байна.



Монгол Улсын Засгийн газраас Үндэсний хөтөлбөр батлах тухай 96 дугаар тогтоолоор "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ыг баталсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг бүрэн хангахад оршино.

Уг хөтөлбөрийн хүрээнд тус хэлтсийн албан хаагчдыг Монгол бичгийн хичээлд хамруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Өлгий сумын улсын бүртгэгчдийн ажлын өрөөнд хүндэтгэлийн булан шинээр байгуулан төрийн далбаа, сүлд байрлуулж шинээр төрсөн, гэрлэсэн иргэдэд гэрчилгээ гардуулах ажлыг ёслол хүндэтгэлтэйгээр гардуулах орчин бүрдүүлэн ажиллав. "ДЭЛХИЙН ГЭР БҮЛИЙН ӨДӨР"-ийг тохиолдуулан гэр бүлээ батлуулсан хосууд, шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн эцэг, эхчүүдэд ёслолтой бүртгэл хийж, гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн үнэ цэнийг сурталчлан гэрлэлтийн гэрчилгээ, төрсний гэрчилгээг хүндэтгэлтэйгээр гардуулсан.



“Хууль зүйн салбарын нээлттэй бодлого” баримт бичгийн хүрээнд 2022 онд Улсын бүртгэлийн еранхий газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Уг төлөвлөгөөнд “Төрийн үйлчилгээ авахтай холбоотой улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй хаяг байршил, бичиг баримтын бүрдүүлэлт, үйлчилгээний үнэ хураамжийн талаарх мэдээлэл агуулсан самбарыг холбогдох үйлчилгээний байранд байршуулж иргэдийг мэдээллээр хангах” гэж заасны дагуу тус хэлтэс нь үйлчилгээний заал, архив, төвийн албан хаагч бүрийн үйлчилгээ үзүүлэх цонхонд мэдээ мэдээллийн самбар байршуулан ажиллаж байна.




Өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараалал харгалзахгүй үйлчилгээ үзүүлдэг зэрэг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон стандартад нийцүүлэн байршуулсан болно.

Үйлчилгээний стандартын шаардлага хангасан хэлтсийн албан өрөөнүүдийн нэр хаягийг монгол бичиг болон кирилл бичгээр бичиж өрөөний үүдэнд байршуулсан.



Сумдын вэб хуудсанд бүртгэлийн үйлчилгээний мэдээлэлтэй цонх оруулж, эхлэн төрийн үйлчилгээний E-mongolia.mn цахим нэгдсэн системд улсын бүртгэлийн байгууллагаас олгосон тоон гарын үсгээр нэвтэрч Улсын бүртгэлийн үйлчилгээ, лавлагаа авах талаар таниулан сурталчилан ажилласан. Ингэснээр иргэд бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг авах олон сувагтай болж байна. Өнөөдрийн байдлаар www.e-mongolia.mn веб сайтаар захиалан гадаад паспорт 16, иргэний цахим үнэмлэх 175 ширхэг хэвлэгдэн ирсэн байна.



Сумдын Засаг даргын Тамгын газартай хэлтсийн дарга хамтран ажиллах хүрээнд сум дахь улсын бүртгэлийн мэдээллийн самбарыг шинэчилэн нэгдсэн нэг стандартад нийцүүлэн баталж өгч, тухайн сумын төсвөөр 13 сумын самбарыг мөн хэлтсийн төвийн мэдээллийн самбарыг шинэчилсэн.



Тухайн мэдээллийн самбарт хууль тогтоомж, журам, тушаал шийдвэр, шударга ёс, хөгжил дэвшилд авлигын эсрэг мэдээ, мэдээлэл, бүрдүүлэх баримт бичиг, үйлчилгээний үнэ хураамж, хүний нөөцийн ил тод байдал, зарлал, санал хүсэлтийн хайрцаг гэсэн агуулгатай ба үүнд:

1. Хууль тогтоомж: Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний улсын бүртгэлийн тухай хууль,
2. Тушаал шийдвэр: Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт, үйлчилгээний хөлсний талаар гарсан тогтоол, тушаал,
3. Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олонд манай хэлтсийн танилцуулга,
4. Улсын бүртгэгчийн мэдээлэл хэсэгт бүртгэгчийн хийх бүртгэл, цагийн хуваарь,
5. Бүрдүүлэх баримт бичиг: бүрдүүлэх материалын жагсаалт брошур,
6. Ажиллах цагийн хуваарь хэсэгт цагийн хуваарь хэлтсийн хаяг веб сайт гэх мэт
7. Зарлал хэсэгт өдөр тутмын иргэдтэй хүргэх зар мэдээ мэдээллийг тавьж байгаа.

Мөн шинэчлэгдсэн гарсан тушаал, шийдвэр, журам, мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна.

Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Ухаалаг засаглал”, “Цахим засаглал”-ыг бий болгох зорилтын хүрээнд, аймгийн төрийн үйлчилгээг цахимаар хүргэж авилгагүй, хүнд сурталгүй, цахим засаглалыг тогтоохоор зорьж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, банкинд очерлаж цаг алдалгүй иргэн өөрөө цахимаар авах боломжийг бүрдүүлж КИОСК машин нэвтрүүлээд байна. Уг машинаас өнөөдрийн байдлаар улсын бүртгэлтэй холбоотой бүртгэл, бүх төрлийн лавлагааг үнэ төлбөргүй авахаас гадна цахим үнэмлэх захиалах, гадаад паспортын зураг илгээх, тоон гарын үсэг авах зэрэг 17 төрлийн үйлчилгээ авах боломжтой юм.

“Цахим засаглал” хөтөлбөрийн хүрээнд хүн ам ихтэй Өлгий, Цэнгэл сумуудад Улсын бүртгэлийн КИОСК машин худалдаж авахаар Засаг дарга нартай УБХ-ийн дарга, Улсын бүртгэгч нарын хамтран байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн

төлөвлөгөөнд тусгасан ажлаа бүрэн хэрэгжүүлж тус бүр 23.000.000 /хорин гурван сая/ төгрөгийн үнэ бүхий өртөгтэй Улсын бүртгэлийн КИОСК машин худалдан авсан. Эхний ээлжинд Өлгий сумын КИОСК машиныг “Нью компас” ХХК-ны захирал Р.Мөнхбаттай бүтээгдэхүүн нийлүүлэлт, суурилуултын гэрээ байгуулан ажиллуулж эхэллээ.



Нью Компас ХХК

Монгол улс, Улаанбаатар 15170, Чингэлтэй Дүүрэг
1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, 3-42
Утас: 99018525, 70119190
И-Мэйл: munkhbat@newcompass.mn



ҮНИЙН САНАЛ		2022 ОНЫ 11 САРЫН 23	
ХАНА	ТАЙЛАР		
Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс – 1 Утас: 99655206	Киоск машины үнийн санал		
№	БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР	ТОО ХЭМЖЭЭ	НЭГЖ ҮНЭ НИЙТ
1	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КИОСК - 22" TFT LCD display 16:9 - Capacitive multipoint touchscreen - Intel Core i7 9 th Gen 2.9Hz, DDR3- 8GB, 256GB SSD HDD, Intel graphics 4600 - 6xUSB, 1xHDMI, 1xDVI, 1xLAN, 1xVGA - Stereo sound 10W+10W - 8cm термо принтер - Хурууны хээ уншигч - А4 принтер - Баркод уншигч - Иргэний үнэмлэх уншигч - Биометрик камер	1	23,800,000 23,800,000
			Нийт үнэ 23,800,000 ₮

ТАЙЛАР:
 Бараа нийлүүлэх хугацаа: 15 - 60 хоног /Гэрээ хийх үед төхөөрөмжийн ноцол болон байх эсжээс хамаарна /
 Үнийн дүнд НӨАТ багтсан.
 Баталгаат хугацаа: 12 САР

ҮНИЙН САНАЛ БОЛОВСРУУЛСАН:



Р.МӨНХБАТ

Орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах хүрээнд Өлгий сумын ЗДТГ-аас Гэрэгэ КИОСК төлбөрийн машин шийдвэрлүүлж байрлуулсан. 2022 онд бүртгэлд хамрагдсан иргэд төлбөр хураамжийн 78 хувийг Гэрэгэ КИОСК-оор төлж цаг хугацаа хэмнэж, төрийн үйлчилгээ шуурхай чирэгдэлгүй авсан байна.

Мөн 2022 онд Дэлүүн, Улаанхус сумын улсын бүртгэгч нар сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Гэрэгэ Киоск цахим төлбөрийн машины болох тус бүр 7,000,000 /долоон сая/ төгрөг шийдвэрлүүлэн, Ногооннуур сум 3,000,000 /гурван сая/ үлдсэн төлбөрийг дараа онд шийдвэрлүүлэхээр Гэрэгэ системс компанитай гэрээ байгуулан суурилуулахаар ажиллаж байна.



Монгол улсад Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 82 жилийн ой, “УЛСЫН БҮРТГЭЛИЙН АЖИЛТНЫ ӨДӨР”-ийг тохиолдуулан Улсын бүртгэлийн хэлтсийн эцэг, эхийн зөвлөлөөс хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас чадварыг дэмжих зорилгоор Аймгийн нийтийн номын сантай хамтран албан хаагчдын хүүхдүүдийн дунд ЗУРАГ ЗУРАХ, УРАН УНШЛАГЫН уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.

Тэмцээн маш сонирхолтой өрсөлдөөнтэй болж өндөрлөлөө. НАМАР сэдвээр зураг зурах, чөлөөт сэдэвт уран уншлагын тэмцээний байр эзэлсэн байдлыг танилцуулвал:

Зураг зурах

Гран при - Рысбай овогтой НУРСУЛТАН

1-р байр Арман овогтой АРУЖАН

2-р байр Ашухан овогтой АЙБИКЕ

3-р байр Имашхан овогтой ЖАННУР

Уран уншлага

1-р байр Рахман овогтой МУСТАФА

2-р байр Мейрамбек овогтой АЛИ

3-р байр Съез овогтой БЕГИМ

3-р байр Ансаган овогтой ЕРГАЛЫМ нар тус тус эзэлсэн болно.



“Хоггүй Өлгий-Цэмцгэр хот” бүх нийтийн их цэвэрлэгээнд 2 удаа оролцож хуваарьт газрыг цэвэрлэсэн ба мод тарих ажилд 2 удаа идэвхтэй оролцож 63 мод тарив.



Бүтээлч ажлын хүрээнд Эд хөрөнгийн тасгаас санаачлан аялал зугаалга, сургалт семинар, баяр ёслолын үеэр өмсөх жигд хувцастай болов.



Хэрэгжсэн бүтээн байгуулалтын ажил: Улсын бүртгэлийн хэлтсийн архив, ажлын байрыг камержуулах

Санхүүгийн эх үүсвэр: ОНХС

Нийт төсөвт өртөг: 4,800,000₮


Нийлүүлсэн: “Их түргэн ачит” ХХК

Хугацаа: 2022 оны 09-р сар

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэж Улсын бүртгэлийн хэлтсийн архив, ажлын өрөөг орчин үеийн хяналтын камер байршуулав. Тус хэлтэс нь Көшелик тоуерийн 0,3,4-р давхарт үйл ажиллагаа явуулдаг. Подваллд архивын өрөө буюу иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн эх нотлох баримтууд хадгалагдаж байгаа. Байгууллагын аюулгүй байдлыг хангасан орчин үеийн гадна, дотно хяналтын камертай болсноор иргэдийн үйлчилгээ авах хяналт, үйл ажиллагааг баримтжуулах, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран гар утас, ухаалаг төхөөрөмж ашиглан хянах боломжтой болсон юм.

1. Хяналтын дотор камер – 10 ширхэг,
2. Хяналтын гадна камер – 2 ширхэг,
3. Зурагт /55инч/ – 1 ширхэг,
4. Бичигч төхөөрөмж -1 ширхэг,
5. Хард диск /4тб/ -1 ширхэг,
6. HDMI кабель /30м/ – 1 ширхэг





Орон нутагт үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажилагааг бэхжүүлэх зорилгоор нууцын зэрэглэлийн баримт бичиг хадгалах сейф 1.550.000 төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах 10.000.000 төгрөгийн санхүүжилтийг аймаг хөгжүүлэх сангаас хувиарлан өгч, аймгийн Засаг дарга “БАТЛАМЖ”-ийг гардуулав.



Арван хоёр. Санал

Улсын бүртгэлийн байгууллагын хараат бус байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй хүргэх боломжийг бүрдүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор дараах асуудлыг санал болгож байна. Үүнд:

1. Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд хүндрэлтэй асуудлын нэг болох Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасан “Иргэний нас барсныг энэ хуулийн 13.2-т заасан этгээд нас барагчийн иргэний болон дурдсан баримт бичгийг аль тохирохыг бүрдүүлж, аймаг, нийслэлд 3, сум, Дипломат төлөөлөгчийн газарт 7 хоногийн дотор бүртгүүлнэ” гэж заасны дагуу Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу 20 нэгжээр торгох асуудал өнөөдөр иргэдийн бодит амьдралд таарахгүй, иргэдийн сэтгэл санаанд нөлөөлсөн, эрхэд халдсан, хүнд асуудал болж байна. Иймд зөвхөн бүртгүүлэх хугацааг аймаг, нийслэлд 15, сум, Дипломат төлөөлөгчийн газарт 30 хоногийн дотор бүртгүүлнэ” гэж нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Иймд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасан бүртгүүлэх хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулах.

2. Хуулийн этгээдийн шинэчилсэн бүртгэлд хамрагдахгүй байгаа нэр бүхий шашны 3 байгууллага, улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй боловч холбогдох хуульд заасан үүргээ биелүүлдэггүй, үйл ажиллагаа явуулдаггүй, төрийн бус байгууллагуудын судалгааг гаргаж үүсгэн байгуулагчид, гүйцэтгэх удирдлагуудад нь мэдэгдэж татан буулгах ажлыг 2023 онд зохион байгуулах.

3. Өөрсдийн нөөц бололцоог ашиглан мэдээллийн санд цахимжаагүй 2006, 2007 оны ИУБ болон ХААТР маягтуудыг цахимжуулах

4. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх эрхийг үлдсэн сумдад өгөх, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн сканнер, принтер шинэчлэх

5. Тус хэлтэст УБЕГ-аас батлагдсан орон тоогоор Хяналтын улсын байцаагчаар нэг ажилтан ажиллаж байгаа нь аймгийн 103 мянган ард иргэдийн бүртгэлийн зөрчлийг арилгахад хүндрэл учирч маш их ачаалалтай илүү цагаар ажиллаж байна. Нөгөөтэйгүүр Хяналтын улсын байцаагчийн ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй, сургалттай байх үед ажлыг нь түр орлон гүйцэтгэх байцаагчийн эрхтэй албан хаагч байхгүй байгаа нь үйлчлүүлэгч иргэдийг цаг хугацааны хувьд чирэгдүүлж байна. Иймд Хяналтын улсын байцаагчийн орон тоог нэмэгдүүлж 2 болгох.

4. Нярав, бичиг хэргийн эрхлэгчийн ажлын ачааллыг харгалзан нярав болон бичиг хэргийн эрхлэгчийн орон тоог хоёр тусад нь салгах, төрийн үйлчилгээний албан хаагчид нь аливаа төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалтад орох боломжгүй төрийн захиргаанд ажиллаагүй гэсэн шалгуураар хасагддаг. Төрийн үйлчилгээний албанд олон жил ажилласан албан хаагчийг төрийн захиргааны албан хаагчтай адилтгах саналыг дээд шатны байгууллагад уламжлуулах саналтай байна.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

